

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/35/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга  
бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954 Цахим хаяг: [Khuanganm@audit.gov.mn](mailto:Khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930 Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

“Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор: Б.Галымбек

Утас: 99101563 Цахим хаяг: [uujimaudit@gmail.com](mailto:uujimaudit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал .....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт .....	16
4.1 Залруулсан алдаа .....	16
4.2 Төлбөрийн акт .....	16
Байхгүй .....	16
4.3 Албан шаардлага .....	16
4.4 Зөвлөмж.....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

БАЯННУУР СУМЫН ХҮҮХДИЙН  
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ  
Б.ЖУЛДЫЗ ТАНАА

2022.02.24 № 133  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл 7**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Цэцэрлэгийн санхүүгийн тайланд тусгасан хүнсний материал бодитоор 7978.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй боловч санхүүгийн тайланд 12858.8 мянган төгрөгийн үлдэгдэл байгаагаар тайлагнасан, санхүүгийн тайланд олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3452.6 мянган төгрөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй авлагыг санхүүгийн тайланд тусгасан зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн 20.2.5, 20.2.6 дахь заалттай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>25435747.65</u></b>	<b><u>33890865.99</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	3861042.00	3861042.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	408438.00	408438.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	3452604.00	3452604.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	3452604.00	3452604.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	21574705.65	30029823.99
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21574705.65	30029823.99
35410	Бичиг хэргийн материал	0.00	35000.00
35420	Аж ахуйн материал	8271050.00	8699494.00
35440	Түлш, шатах тослох материал	144632.00	632.00
35460	Хүнсний материал	4723187.65	12858861.99
35470	Бусад хангамжийн материал	8435836.00	8435836.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>264622314.80</u></b>	<b><u>245987447.07</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	264622314.80	245987447.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	252112314.80	233477447.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	241049883.28	241049883.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-7714997.04	-15429994.08
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	23544908.00	24629408.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19978068.66	-20174048.70
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	51335428.00	51335428.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44153150.12	-51114241.43
39214	Бусад үндсэн хөрөнгө	16625741.34	16625741.34
39215	Хуримтлагдсан элэгдэл	-11403210.00	-16344509.34
39217	Ном	2805780.00	2899780.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	12510000.00	12510000.00
39301	Програм хангамж	550000.00	550000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550000.00	-550000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	12510000.00	12510000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>290058062.45</u></b>	<b><u>279878313.06</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4014498.20</u></b>	<b><u>1217686.20</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4014498.20	1217686.20
<b>413</b>	<b>Өглөг</b>	4014498.20	1217686.20
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	24500.00	24500.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	3405979.20	1193186.20
41361	Байгууллагад төлөх өглөг	2298868.00	86075.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1107111.20	1107111.20
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>286043564.25</u></b>	<b><u>278660626.86</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	286043564.25	278660626.86
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	73650520.00	73650520.00

51101	Өмч: - төрийн	73650520.00	73650520.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-32609283.49	-39992220.88
51210	Өмнөх үеийн үр дүн	-32609283.49	-32609283.49
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-7382937.39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245002327.74	245002327.74
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>290058062.45</u></b>	<b><u>279878313.06</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>431,595,200.00</b>	<b>448,824,600.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,499,000.00</b>	<b>-</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	3,499,000.00	-
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>428,096,200.00</b>	<b>448,824,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	399,143,300.00	421,886,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399,143,300.00	421,886,700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28,952,900.00	26,937,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28,952,900.00	26,937,900.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>433,896,852.43</b>	<b>456,207,537.39</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>433,896,852.43</b>	<b>456,207,537.39</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	429,267,552.43	455,594,308.39
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	321,898,577.00	346,496,732.00
210101	Үндсэн цалин	321,898,577.00	311,089,832.00
210104	Урамшуулал		22,966,300.00
210105	Гэрээт ажлын хөлс		- 12,440,600.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	37,099,244.00	36,227,297.00
210201	Тэтгэврийн даатгал	37,099,244.00	36,227,297.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,058,500.00	26,738,500.00
210301	Гэрэл, цахилгаан	1,131,900.00	1,131,900.00

210302	Түлш, халаалт	27,926,600.00	25,606,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,462,395.00</b>	<b>1,965,200.00</b>
210401	Бичиг хэрэг	627,800.00	387,800.00
210402	Тээвэр, шатахуун	881,995.00	666,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412,500.00	457,000.00
210404	Ном, хэвлэл	75,300.00	44,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,464,800.00	410,400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>26,609,508.50</b>	<b>22,103,855.66</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	259,300.00	173,000.00
210502	Хоол, хүнс	25,565,408.50	21,454,855.66
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	784,800.00	476,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>10,000.00</b>	<b>350,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,000.00	-
210604	Урсгал засвар	-	350,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>124,000.00</b>	<b>344,400.00</b>
210702	Дотоод албан томилолт	124,000.00	344,400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>300,000.00</b>	<b>396,500.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		146,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	250,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>10,705,327.93</b>	<b>20,971,823.73</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,092,500.00	1,158,456.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,612,827.93	19,813,367.73
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,629,300.00</b>	<b>613,229.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,629,300.00</b>	<b>613,229.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,629,300.00	613,229.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(2,301,652.43)</b>	<b>7,382,937.39</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>2,301,652.43</b>	<b>(7,382,937.39)</b>

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>				0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>				0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
C07	Тайлант үеийн үр дүн				0.00
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>73,650,520.00</b>	<b>245,002,327.74</b>	<b>-32,609,283.49</b>	286,043,564.25
D01	<b>2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>73,650,520.00</b>	<b>245,002,327.74</b>	<b>-32,609,283.49</b>	286,043,564.25
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>73,650,520.00</b>	<b>245,002,327.74</b>	<b>-32,609,283.49</b>	286,043,564.25
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-7,382,937.39	-7,382,937.39
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>73,650,520.00</b>	<b>245,002,327.74</b>	<b>-39,992,220.88</b>	278,660,626.86

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>428096200.00</b>	<b>448824600.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>428096200.00</b>	<b>448824600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	399143300.00	421886700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	399143300.00	421886700.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	28952900.00	26937900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	28952900.00	26937900.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>427746961.35</b>	<b>447646100.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>427746961.35</b>	<b>447646100.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>423117661.35</b>	<b>447032871.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	318151800.00	339938848.00
210101	Үндсэн цалин	282507172.00	303672847.00
210104	Урамшуулал	22470500.00	22966300.00
210105	Гэрээт ажлын хөлс	13174128.00	13299701.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44240000.00	43369200.00
210201	Тэтгэврийн даатгал	31724400.00	30519000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3128900.00	3212500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2503100.00	2570100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	625800.00	642500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6257800.00	6425100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	28952900.00	26507000.00
210301	Гэрэл, цахилгаан	1131900.00	1131900.00
210302	Түлш, халаалт	27821000.00	25375100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3779200.00	2537044.00
210401	Бичиг хэрэг	627800.00	390400.00
210402	Тээвэр, шатахуун	1198800.00	666000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	412500.00	457000.00
210404	Ном, хэвлэл	75300.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1464800.00	1023644.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	25826500.00	33319723.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	209300.00	78100.00
210502	Хоол, хүнс	24832400.00	32606923.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	784800.00	634700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	50761.35	210000.00
210604	Урсгал засвар	50761.35	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	124000.00	344400.00
210702	Дотоод албан томилолт	124000.00	344400.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	300000.00	396500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		146500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1692500.00	410156.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1692500.00	410156.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4629300.00</b>	<b>613229.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4629300.00	613229.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4629300.00	613229.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>349238.65</u></b>	<b><u>1178500.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>400000.00</b>	<b>1178500.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>400000.00</b>	<b>1178500.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	400000.00	1178500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	400000.00	1178500.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-400000.00</u></b>	<b><u>-1178500.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-50761.35	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	50761.35	
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	448824600.00	448211371.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	448824600.00	448211371.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	448824600.00	448211371.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	339952700.00	339938848.00
210101	Үндсэн цалин	304545800.00	303672847.00
210104	Урамшуулал	22966300.00	22966300.00
210105	Гэрээт ажлын хөлс	12440600.00	13299701.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	43369200.00	43369200.00
210201	Тэтгэврийн даатгал	30519000.00	30519000.00
210202	Тэтгэмжийн даатгал	3212500.00	3212500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2570100.00	2570100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	642500.00	642500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6425100.00	6425100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26727900.00	26507000.00
210301	Гэрэл, цахилгаан	1131900.00	1131900.00
210302	Түлш, халаалт	25596000.00	25375100.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2993000.00	2660900.00
210401	Бичиг хэрэг	390600.00	390400.00
210402	Тээвэр, шатахуун	666000.00	666000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	457000.00	457000.00
210404	Ном, хэвлэл	87900.00	94000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1391500.00	1053500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	33319900.00	33319723.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	78100.00	78100.00
210502	Хоол, хүнс	32607100.00	32606923.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	634700.00	634700.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	210000.00	210000.00
210604	Урсгал засвар	210000.00	210000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	390600.00	344400.00
210702	Дотоод албан томилолт	390600.00	344400.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	396500.00	396500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	146500.00	146500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250000.00	250000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1464800.00	1464800.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1464800.00	1464800.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.0	1.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	32.00	32.00

620001	Удирдах ажилтан	1.0	1.0
620002	Гүйцэтгэх ажилтан	16.0	16.0
620003	Үйлчлэх ажилтан	12.00	12.00
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00

Төгрөгөөр

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Уужим алтай Аудит” ХХК-ны аудитор Б.Галымбек гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар хэрэгжүүлсэн.

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл

Хүүхдийн хөгжлийг бүх талаар дэмжиж , сургах үйлийг дадал болгох сургалтыг олон талд шинэлэг арга хэлбэрийг хослуулан сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тайлант онд Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийгдсэн байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 435.8 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр буюу 3.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		0.00	0.00
Авлага	3861.0	3861.0	0.00
Урьдчилгаа	0.0	0.0	0.00
Бараа материал	21574.7	30029.8	8455.1
Үндсэн хөрөнгө	264622.3	245987.4	-18634.9
<b>Нийт хөрөнгө</b>	<b>290058.0</b>	<b>279878.3</b>	<b>-10179.8</b>
Өр төлбөр	4014.5	1217.7	2796.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>286043.5</b>	<b>278660.6</b>	<b>-7383.0</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>290058.0</b>	<b>279878.3</b>	<b>-10179.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 30.0 сая төгрөг болж 8.4 сая төгрөгөөр өссөн нь хүнсний материалын үлдэгдэл өссөнтэй холбоотой байна. Хүнсний материал данс 4.7 сая төгрөгийн, аж ахуйн материалын данс 12.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Санхүүгийн тайлангаар хүнсний материал дансанд оны эхэнд 4.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба 28.3 сая төгрөгийн хүнс худалдан авч 20.2 сая төгрөгийн материалыг зарцуулж жилийн эцэст 12.8 сая төгрөгийн хүнсний материалын үлдэгдэлтэй

тайлагнасан байна. Хүнсний материалын үлдэгдэл нэмэгдсэн нь цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссонтой холбоотой чанар байдал алдаж муудах эрсдэлтэй байна.

Үдсэн хөрөнгө дансны үлдэгдэл 245.9 сая төгрөг болж 18.6 сая төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 1.2 сая төгрөгөөр өсөж, үндсэн хөрөнгөд 19.8 сая төгрөгийн элэгдэл байгуулснаас шалтгаалжээ.

Тайлант оны эцэст өр төлбөргүй байна. Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 278.6 сая төгрөг болж 7.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны анх батлагдсан төсөв 462.6 сая төгрөг, тодотгосон төсөв 448.8 сая төгрөг байна.

Тодотгосон төлөвлөгөө нь анх баталсан төлөвлөгөөнөөс 13.8 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Үүнд: Цалин, хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 18.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, норматив зардал буюу хоолны зардлыг 32.5 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд 448.8 сая төгрөгийн төсөв баталснаас 421.8 сая төгрөгийг улсын төсвөөс 26.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 448.8 сая төгрөгийн санхүүжилт авч үйл ажиллагаандаа 448.2 сая төгрөгийг зарцуулж, 0.6 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Түлш, халаалтын зардлыг 0.25 сая, хангамж, бараа материалын зардлыг 0.35 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Хоолны зардлын төсвөөс 1.0 сая төгрөгийг санхүүгийн хяналт аудитын албаны актад зориулалт бус шилжүүлсэн байна.

Нийт төсвийн 75.7 хувийг цалин, 9.6 хувийг НДШ-ийн зардал, 5.9 хувийг тогтмол зардал, 0.6 хувийг хангамж бараа материалын зардал, 7.4 хувийг норматив зардал, 0.04 хувийг урсгал засварын зардал, 0.1 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 0.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 0.2 сая төгрөгийн нэмэлт төсөв авч хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгахад зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны төсөвт дүн шинжилгээ хийж үзэхэд үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай цалингийн зардалд 339.9 сая төгрөг, НДШ-ийн зардалд 43.3 сая төгрөг, халаалтын зардалд 26.7 сая төгрөг, урсгал засвар, эмийн зардалд 0.3 сая төгрөг, хоолны зардалд 32.6 сая төгрөг нийтдээ 442.8 сая төгрөг зарцуулсан байна.

Нийт санхүүжилтийн орлого 448.8 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлыг хасахад 6.0 сая төгрөгийн зардлыг тэвчиж болох зардал гэж үзээд тогтоолын дагуу 0.6 сая төгрөгийг хэмнэх тооцоо гарч байгаа ба оны эцэст 0.6 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн тул Засгийн газрын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын хэрэгжилт хангагдсан гэж үзлээ.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх, материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө дараах бүхий эрсдэлтэй асуудал байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар жилийн эцсийн эд хөрөнгийн толлогын бүртгэлээр хүнсний материал үлдэгдэлгүй боловч санхүүгийн тайлангаар 4.7 сая төгрөгийн үлдэгдэл байгаагаар тайлагнасан, энэхүү зөрчилд 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, мөн олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3.8 сая төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчилд дахин албан шаардлага өгсөн байна.

Цэцэрлэгийн удирдлага, санхүүгээс дээрх зөрчлийг шийдвэрлэх талаар ямар ч арга хэмжээ аваагүй ба оны эцсээр цэцэрлэгийн эрхлэгч өндөр насны тэтгэвэрт гарч, нягтлан бодогч нь өөрчлөгдсөн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэгийн 2021 онд нийт 372.2 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 448.8 төгрөгийн 145 мэдээллийг хугацаандаа байршуулж, 2 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан, 2

мэдээллийг буюу 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт байршуулах хугацаа болоогүй байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хүнсний материалын үлдэгдэлтэй холбоотой 4.7 сая төгрөгийн, олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3.8 сая төгрөгийн авлагатай холбоотой зөрчлийг шийдвэрлэх талаар албан шаардлага, шилэн данстай холбоотой 1 зөвлөмж өгөгдсөн байна. Давтан шалгаж үзэхэд албан шаардлагын хэрэгжилтийг хангуулаагүй, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Хүнсний материалын үлдэгдэл их хэмжээгээр нөөцөлсөн нь анхаарах асуудал байна гэж үзлээ.

## **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар нийт 8.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 8.3 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

### **4.1 Залруулсан алдаа**

Байхгүй

### **4.2 Төлбөрийн акт**

Байхгүй

### **4.3 Албан шаардлага**

Аудитаар 8.3 сая төгрөгийн материаллаг зөрчил илэрч зөрчил арилгуулах албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Цэцэрлэгийн жилийн эцсийн бараа материалын тооллогын бүртгэлээр 7978.4 мянган төгрөгийн хүнсний материал тоологдсон боловч санхүүгийн тайланд 12858.8 төгрөгийн үлдэгдэл байгаагаар тусгаж, үлдэгдлийг 4880.4 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. Мөн санхүүгийн тайланд олон жил он дамжсан хувь хүмүүстэй холбоотой 3452.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах арга хэмжээ аваагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй тайлагнасан байна. Бараа материалын үлдэгдэлд байгаа зөрүү болон авлагатай холбоотой дээрх зөрчлийг арилгах талаар өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузл суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ, 20 дугаар зүйлийн 20.2 “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн

болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, оршин байх, эрх ба үүрэг, толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хүнсний материалын үлдэгдлийн зөрүү болон олон жил он дамжсан найдваргүй авлагыг шийдвэрлэх талаар зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

#### 4.4 Зөвлөмж

Байхгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баяннуур сумын хүүхдийн цэцэрлэг	1	8.3					1	8.3		